



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 1/95

Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа болон хаягжуулалтын тухай хуулийн дагуу шинэ хаяг авсан 3 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын засаг дарга (Р.Мөнхтогтох), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 32, 2009 оны 235 дугаар захирамжийн хавсралтын 22, 2012 оны 235 дугаар захирамжийн хавсралтын 2 дэх заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс (Ж.Өлзийжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

488190239

Дундговь аймгийн Засаг даргын 2019 оны... дугаар сарын...  
 дугаар захирамжийн хавсралт



| № | Өмчлөгчийн |            |                   | Өмнөх захирамжийн |                          | Өмнөх газрын   |             |             | Газрын           |         |
|---|------------|------------|-------------------|-------------------|--------------------------|----------------|-------------|-------------|------------------|---------|
|   | Овог       | Нэр        | Регистрийн дугаар | Огноо дугаар      | Холбогдох хэсгийн дугаар | Байршил        | Хэмжээ /м2/ | Хэмжээ /м2/ | Хэмжээ /м2/      | Байршил |
| 1 | Энэбиш     | Жигжид     | 3Ю77092071        | 2005 №319         | 32                       | Боржигон 21-1  | 600         | 791         | Боржигон 23-2301 | 2531200 |
| 2 | Гаваа      | Энхжаргал  | 3К77032409        | 2012 №235         | 2                        | Боржигон 22-1а | 717         | 943         | Боржигон 24-2401 | 3017600 |
| 3 | Муунохой   | Байгальмаа | 3374120408        | 2009 №236         | 22                       | Мандал 16-17   | 875         | 1185        | Мандал 18-1838   | 3792000 |